



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 5/08

Хэрлэнбаян-Улаан тосгон

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган, идэвхи санаачлага, үр бүтээлтэй ажилласан нягтлан бодогч Ю.Батбаярт 03 дугаар сарын ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцож олгосугай.

2. Нягтлан бодогч Ю.Батбаярын ур чадварын нэмэгдлийг зохих журмын дагуу олгохыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОТГОНБАЯР